



## **МЭНДЧИЛГЭЭ**

Монгол Улсад Санхүүгийн тагнуулын алба үүсэн байгуулагдаад 5 жил болж байна. Өнгөрсөн 5 жилийн хугацаанд биднийг дэмжиж хамтарч ажилласан Монголбанкны хамт олон, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүд, нийт банк, санхүүгийн байгууллагын ажиллагсад болон харилцагч та бүхэндээ эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөж, чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлж байна.

Манай алба Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, олон улсын стандарт, шаардлагыг Монгол Улсад нэвтрүүлэх улмаар банк, санхүүгийн системийн тогтвортой байдал, найдвартай ажиллагааг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлж ирлээ.

Энэ 5 жилийн хугацаанд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг банкны салбарт хэвшүүлэхэд гол анхаарлаа хандуулснаар чамлахааргүй ажлууд хийж гүйцэтгэсэн гэдгийг онцолмоор байна. Цаашид банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудад хүрч ажилласнаар Монгол Улсын банк, санхүүгийн системээр гэмт хэргийн гаралтай бохир мөнгө нэвтрэх боломж олгохгүй байж, гадаадын банк санхүүгийн байгууллагын итгэлийг хүлээсэн банк санхүүгийн системийг бий болгохыг эрхэм зорилгоо болгон ажиллах болно. Энэ хугацаанд бид бүхэнтэй хамтран ажиллаж, энэ үйл ажиллагааг дэмжиж ирсэн Та бүхэндээ Санхүүгийн тагнуулын алба үүсч хөгжсөний 5 жилийн ойн халуун мэндийг хүргэж, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

**МОНГОЛБАНКНЫ САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН  
АЛБАНЫ ДАРГА Б.ТӨМӨРБАТ**